



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/24

Сүхбаатар сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."г", Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15.1, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.7, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 72 дугаар тогтоолоор баталсан "Багш, сурагч солигцоо" хөтөлбөрийн 2.1. 2.2 дахь дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн үндэсний лаборатори ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн хими биологийн багш Г.Цолмонгийн Япон Улсын Окаяма хстод 2019 оны 07 дугаар сарын 14-21-ний хооронд болох "Тогтвортой хөгжил-хичээлийн судалгаа" чиглэлээр туршлага судлах арга хэмжээнд хамрагдах хүсэлт, орон нутгийн чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх бодлого зорилтыг хэрэгжүүлэх, түүний өндөр хөгжилтэй срны мэргэжлийн багш нараас суралцах эрмэлзлэлийг дэмжих зорилгоор замын зардалд зориулан нэг удаагийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 2.000.000 /хоёр сая/ төгрөгийг аймгийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн зардал"-аас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Мөнхбаяр/-т зөвшөөрсүгэй.

3. Зардлын тайланг 2019 оны 07 дугаар сарын 24-ний дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг аймгийн үндэсний лаборатори ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн хими биологийн багш /Г.Цолмон/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

My Doc Zahiramj

00000244